

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2018-2025)

УЛААНБААТАР
2017

Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнг
2018-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө

Стратеги төлөвлөгөөтэй холбоотой санал, хүсэлтийг дараах утас, факс, цахим шуудангаар ирүүлнэ үү.

Утас: 11 450480, 99005402
Факс: 11 451762
e-mail: gaabilguudei@gmail.com

АГУУЛГА

Оршил 5

Ерөнхий зорилт 5

Алсын хараа 6

Эрхэм зорилго 6

Үүрэг 6

Нэр төр 6

Үнэт зүйлс .....6**Error! Bookmark not defined.**

Нэг. Стратеги төлөвлөгөө боловсруулах үндэслэл, ач холбогдол 7

1.1. Үндэслэл 7

1.2. Үндсэн зарчмууд..... 7

1.3. Ач холбогдол 8

Хоёр. Хүрээлэнгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ 9

2.1. Хүрээлэнгийн үүсэл хөгжил 9

2.2. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал..... 9

2.2.1. Хүрээлэнгийн бүтэц, чиг үүрэг..... 10

2.2.2. Судалгаа, боловсруулалтын ажил гүйцэтгэх чадамж 11

2.2.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны орц-гарцын шинжилгээ..... 12

2.2.4. Хүрээлэнгийн үйл ажиллагааны SWOT шинжилгээ 13

Гурав. Хүрээлэнгийн стратеги зорилт (2018 – 2025 он), түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт 14

Стратегийн зорилт - 1 15

Стратегийн зорилт - 2 15

Стратегийн зорилт - 3 16

Стратегийн зорилт - 4 17

Дөрөв. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатууд 18

4.1. Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө 18

4.2. Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээний төлөвлөгөө..... 19

Тав. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээ, боломж .. Error! Bookmark not defined.

5.1. Дотоод хүрээ, боломж 20

5.2. Гадаад хүрээ, боломж..... 20

Зургаа. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хяналт, үнэлгээ 21

6.1. Стратеги зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтууд, төлөвлөгөөт арга хэмжээ..... 21

6.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүжилт..... 25

6.3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт..... 27

Хавсралт 33

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Г.Билгүүдэйн үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө..... 33

ОРШИЛ

“ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн стратеги төлөвлөгөө” /цаашид *Стратеги төлөвлөгөө* гэх/ боловсруулахдаа Шинжлэх Ухааны Академийн Эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад холбогдох хууль тогтоомжийн нийтлэг шаардлагад нийцүүлэн төрөөс Шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр, ШУА-ийн ерөнхийлөгч, академич Д.Рэгдэлийн мөрийн хөтөлбөр, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн (цаашид *Хүрээлэн* гэх)-гийн захирал, доктор, профессор Г.Билгүүдэйн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор боловсрууллаа.

Стратеги төлөвлөгөөг ШУА-ийн Тэргүүлэгчдийн Газраас өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа:

- Хүрээлэнгийн түүхэн хөгжил
- Хүрээлэнгийн чиг үүрэг
- Хүрээлэнгийн үйл ажиллагааны өнөөдрийн төлөв байдал
- Шинжлэх ухааны салбарын төрийн бодлого, хууль, эрх зүйн орчны шинэчлэл ба Хүрээлэн
- Хүрээлэнд хэрэгжүүлсэн төслүүд, үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ

гэсэн судалгаануудыг явуулсан болно.

Энэхүү стратеги төлөвлөгөөнд Хүрээлэнгийн хөгжлийн түвшин, өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хийгдэх судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ, алс хэтийн зорилт, төлөв байдлыг баримжаалж, түүнд хүрэх арга замуудыг тодорхойлон тогтоов. Стратеги төлөвлөгөөг 2018-2021 онд хэрэгжих нэгдүгээр, 2022-2025 онд хэрэгжих хоёрдугаар гэсэн үе шаттай байхаар тооцож боловсруулав.

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүрээлэнгийн дунд хугацааны буюу 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, мөн жил бүрийн үр дүнгийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд эдгээр төлөвлөгөөний биелэлт, түүнд хийсэн дүн шинжилгээг үндэслэн стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах замаар түүнийг сайжруулан шинэчилж байх болно.

ЗАХИРАЛ, ДОКТОР, ПРОФЕССОР Г.БИЛГҮҮДЭЙ

ЕРӨНХИЙ ЗОРИЛТ

Хүрээлэнгийн “Алсын хараа”, “Эрхэм зорилго”, “Үүрэг”, “Нэр төр”, “Үнэт зүйлс”-ийг дараах байдлаар тодорхойллоо.

АЛСЫН ХАРАА: Монгол хэл, утга зохиол судлалаар дэлхийд тэргүүлэгч эрдэм шинжилгээний байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Үндэсний хэл бичиг, утга зохиол судлалын уламжлал шинэчлэлийг хослуулсан эрдэм шинжилгээний шилдэг бүтээл туурвина.

ҮҮРЭГ:

- Эрдмийн хамт олонд хэл бичгийн шинжлэх ухааны интеграцийн төв болох нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Дэлхийн монгол судлалын тэргүүн эгнээнд жагсах
- Шинэ санаа, инновацийн дундаршгүй эх булаг байх

НЭР ТӨР:

- Монгол хэл бичгийн судалгааг онолын өндөр түвшинд хийж хэрэгжүүлэдэг мэдлэг оюуны чансаа өндөртэй судалгааны байгууллага
- Шинжлэх ухаан, амьдралд тулгамдаж буй асуудлыг шинэ мэдлэг шингэсэн, үр өгөөжтэй, өвөрмөц содон аргаар шийдвэрлэдэг үйлчилгээний байгууллага

ҮНЭТ ЗҮЙЛС:

- Уламжлалт дэг сургууль
- Эрдмийн эрх чөлөө
- Судлаачийн ёс зүй
- Бүтээлч хамт олон
- Хүний болон оюуны өв хөрөнгө

НЭГ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, АЧ ХОЛБОГДОЛ

1.1. Үндэслэл

“ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн стратеги төлөвлөгөө” /цаашид Стратеги төлөвлөгөө гэх/-г Шинжлэх Ухааны Академийн Эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Соёлын тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, ШУА-ийн Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тодорхой үзэл баримтлалуудад нийцүүлэн боловсрууллаа.

Энэхүү Стратеги төлөвлөгөөнд Хүрээлэнгийн үүсэл хөгжил, өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж цаашид хүрээлэнгээс хийж хэрэгжүүлэх судалгаа боловсруулалтын ажлын хүрээ цараг баримжаалж, алс хэтийн хараа, эрхэм зорилгыг тодорхойлж, түүнд хүрэх зорилт, үйл ажиллагааг төлөвлөж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, шат дарааллыг тооцон шинжилсэн болно.

1.2. Үндсэн зарчмууд

Тус стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үндсэн зарчмуудыг баримталсан болно. Үүнд:

- Хүрээлэнгийн түүхэн туршлагад тулгуурлан, одоогийн үйл ажиллагааны оноо, алдаанд дүн шинжилгээ хийж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн баримжаалж цаашдын үр дүнгээ бодитоор төлөвлөх
- Ойролцоо чиг үүрэг бүхий дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагуудын талаар судалж, нэг талаар хамтран ажиллах боломж, нөгөө талаар харилцан өрсөлдөх чадвараа зөв тооцох
- Хүрээлэнгийн судалгаа боловсруулалтын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, бизнесийн болон хувийн хэвшлийн оролцоотой захиалгат судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх
- Судалгаа шинжилгээний хэрэгжиж буй сэдэв, төслийн ач холбогдол, үр ашгийг үнэн зөв тооцох, дүн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, шинэчлэлт өөрчлөлт хийх, судалгааны шинэ чиглэл бий болгох талаар Хүрээлэнгийн эрдмийн хамт олноор ил тод хэлэлцэх
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын үр ашиг, дүнг хэлэлцэн үнэлэх, төсвөөс гадуурх олон талт санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ тодорхой ойлгомжтой, хийснийхээ хирээр урамшуулагддаг байх зэрэг болно.

1.3. Ач холбогдол

Энэхүү стратеги төлөвлөгөөний нэгдүгээр үе шатыг хэрэгжүүлэн дүгнэх үе нь манай ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн түүхт 100 жилийн тэмдэглэлт ойтой давхцах юм.

Тиймээс тус стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлснээр хүрээлэнгийн ирэх найман жилд баримтлах үйл ажиллагааны зорилго, чиглэл, арга замуудыг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг оновчтой зохион байгуулж, хүрээлэнгийн судалгааны төвшин, хүрэх үр дүнг дээшлүүлж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг төлөвлөгөөний дагуу ханган, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлэн, улмаар өдөр тутмын ажил амжилттай, хариуцлагатай явагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй бидний хувьд Хүрээлэнгийнхээ өв тэгш ойг сэтгэл тэнүүн, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэхийн нэгэн гол хүчин зүйл болох ач холбогдолтой гэж үнэлж байна.

ХОЁР. ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хүрээлэнгийн үүсэл хөгжил

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нь 1921 оны 11 сарын 19-д Судар бичгийн хүрээлэнгийн Дуун ухааны тасаг нэртэйгээр анх байгуулагджээ. Тус хүрээлэнд манай үе үеийн нэрт эрдэмтэд, үндэсний сэхээтнүүд ажиллаж ирсэн ба гадаадын олон монголч эрдэмтэн хамтран ажиллаж ирэв. Тухайлбал, О.Жамъян, С.Шагж, Я.Цэвэл, Ц.Бат-Очир гүн, А.Амар, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ш.Лувсанвандан, А.Лувсандэндэв, Х.Лувсанбалдан, Э.Вандуй, Б.Содном, П.Хорлоо, Д.Ёндон, Х.Сампилдэндэв, Л.Хүрэлбаатар, Д.Цэрэнсодном, Д.Төмөртогоо, Л.Болд нарын нэрт эрдэмтдийн хөдөлмөр бүтээлийг онцлон дурдаж болно.

Хэл зохиолын хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа эхлэн монгол хэлний үгийн сан, хэлзүй, толь бичгийн иж бүрэн судалгаа, Монголын эртний болон орчин үеийн судалгаа, шүүмж судлал, Монголын уран зохиолын харилцаа холбоо, сурвалж судлалын чиглэлээр голлон ажиллаж, үндэсний боловсон хүчин бэлтгэх, шаардлагатай сурах бичиг, гарын авлагаар хангах талаар анхаарал тавьж ирсэн билээ. Тухайлбал, С.Шагжийн зохиосон “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол хэлний тайлбар Чандманийн эрих” толь бичиг, бүх нийтийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх талаар “Хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл” цуврал, “Монголын нууц товчоо” /Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг/, “Орос-Монгол толь” /1957/, Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” /1966/, Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нар “Орос-Монгол толь”, “Орчин цагийн монгол хэлний зүй” /1966/ зэрэг бүтээлүүдийг онцлон тэмдэглүүштэй. Түүнчлэн 1941 оноос эхлэн хэрэгжүүлсэн шинэ үсэг – кирилл бичиг боловсруулах, зөв бичих зүйн дүрэм зохиох, бүх нийтийг бичиг үсэгт сургах ажлыг гардан зохион байгуулж амжилттай хэрэгжүүлсэн тул тус хүрээлэнг 1971 онд ЮНЕСКО алтан медалиар шагнасан юм. Түүнчлэн академич Ц.Дамдинсүрэн, академич А.Лувсандэндэв нарын зохиосон 55 мянга орчим толгой үгтэй Орос-Монгол толийг судлаачид Москва-Улаанбаатарыг холбосон төмөр замаас дутуугүй ач холбогдолтой хэмээн дүгнэсэн байдаг. Мөн “БНМАУ-ын угсаатны зүй, хэл шинжлэйн атлас” /1972/, “Монголын уран зохиолын тойм” /3 боть/, “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” /4 боть/, “Орчин цагийн монгол хэлний үгийн сан судлалын үндэс”, “Улсын нэр томъёоны комиссын мэдээ” /147 боть/, “Монгол аман зохиолын чуулган” /42 боть/ зэрэг томоохон бүтээлүүд туурвисан билээ. Сүүлийн үед тус хүрээлэнгийн хамт олон 120 мянга орчим үг хэллэг багтаасан “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” /5 боть/, “Монгол хэлний цахим их тайлбар толь” /mongoltoli.mn/ болон түүний гар утасны хувилбар зохиож олон нийтэд хүргэсэн.

2.2. Хүрээлэнгийн хөгжлийн төлөв байдал

2.2.1. Хүрээлэнгийн бүтэц, чиг үүрэг

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн “Хэл шинжлэлийн салбар”, “Утга зохиол судлалын салбар”, “Хэрэглээний хэл шинжлэлийн салбар”, “Төвд хэлт утга зохиол судлалын салбар”, “Аман зохиол судлалын салбар”, “Алтай судлалын салбар” гэсэн зургаан салбар, “Монголын нууц товчоо судлалын төв” гэсэн нэг төв, “Дуун ухааны сан хөмрөг”, “Ц.Дамдинсүрэнгийн гэр музей” гэсэн хоёр лаборатори нэгжтэй, нийт 50 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.



Зураг №1. Хэл зохиолын хүрээлэнгийн бүтэц

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай 27 дугаар тогтоол, БСШУ-ны сайдын 2012 оны А/337 дугаар тушаалд заасан ёсоор Хэл зохиолын хүрээлэн нь дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

1. Монгол хэлний нэгжүүд, түүний бүтэц тогтолцоо, хэв шинж, хэлзүйн ай, тэдгээрийн онцлог, үүргийг орчин үеийн хэл шинжлэл ба монгол хэлний онолын уламжлал шинэчлэлийн хүрээнд авч үзэн монгол хэл, хэлнүүд, тэдгээрийн нутгийн аялгууг тусгайлан болон харьцуулан судлах;

2. Монгол хэлний үгийн сангийн үүсвэр бүрэлдэхүүн, түүний гарал, хөгжин баяжих арга замыг тодруулан гаргаж, монгол хэлний журамласан болон тайлбар, мөн орчуулгын хийгээд олон хэлний толь бичиг боловсруулах, монгол хэлтэй төрөл ба төрөл бус хэлнүүд хэрхэн холбогдох асуудлыг судлах;

3. Монгол нэр томьёо оноон тогтоож ирсэн уламжлал, зарчим, тогтолцоог боловсруулах, хэл эзэмших, сурах, сургах онолынүндэслэл, хэлний хэрэглээ-соёлын судалгаа явуулах;

4. Монголчуудын бичиг үсэг, монгол хэлний бичгийн болон аман ярианы дурсгалыг цуглуулах, хадгалах, судлах;

5. Бүх нийтийн эх хэлний болон гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх онол-практикийн үндэслэлийг боловсруулах, төрөөс баримтлах хэлний бодлогыг боловсруулах;

6. Монгол аман болон бичгийн уран зохиолын туурвил зүй, онол, түүх, төрөл зүйл, хэв шинж, зан үйлийн хамаарлыг судлах;

7. Монголын орчин үеийн уран зохиолын төрөл зүйл, төлөөлөгч, уран сайхны онцлог, монгол утга зохиолын харилцаа холбоог судлах;

8. Монгол үндэстнүүдийн утга зохиолын хөгжил, түүх, Монголын эрт болон эдүгээгийн утга зохиолын эх бичиг, сурвалжийн судалгаа хийх;

9. Төвд хэлт монгол уран зохиолын харилцан нөлөөлөл, зохиол бүтээлийг судлах зэрэг болно.

Хүрээлэн нь дараах хоёр зөвлөлтэй байна. Эрдмийн зөвлөл нь нийт 17 гишүүнтэй. Түүнээс 12 гишүүн нь Хүрээлэнгийн эрдэмтэд, 5 гишүүн нь их, дээд сургууль, гадны байгууллагын эрдэмтэд байна.

Захиргааны зөвлөл нь нийт 9 гишүүнтэй. Хүрээлэнгийн дотоод журмаар удирдлага, захиргаа санхүү, ҮЭ-ийн дарга оролцсон байна. Захиргааны удирдлагыг захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбарын дарга нар, мэргэжил, арга зүйн удирдлагыг төслийн удирдагчид хэрэгжүүлнэ.

2.2.2. Судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх чадамж

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нийт 50 ажилтантнаас 47 нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Эрдэм шинжилгээний чадамжийн талаас авч үзвэл академич 3, шинжлэх ухааны доктор (Sc.D) 2, доктор (Ph.D) 26, магистр 13 (докторант 6) байх бөгөөд нийт эрдэм шинжилгээний ажилтны 66 хувь нь доктор (Ph.D) болон түүнээс дээш зэрэгтэй байна. Эрдэм шинжилгээний ажилтны насны бүтцийг үзвэл 35 хүртэлх насныхан 34 хувийг, 35-50 насныхан 38 хувийг, 50-аас дээш насныхан 28 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл тус хүрээлэнгийн эрдмийн хамт олныг ахмад, дунд, залуу үеийнхэн харьцангуй тэнцвэртэй бүрдүүлж байх бөгөөд дундаж нас 42.6 байгаа нь уг хамт олон ерөнхийдөө онол, арга зүйн талаар төлөвшиж, ид бүтээн туурвих чадамж бүрдээд байгааг харуулж байна.

Академич	Доктор (Sc.D)	Доктор (Ph.D)	Доктор болон түүнээс дээш зэрэгтэй ЭША (%)	Магистр	Докторант
3	2	26	66	7	6

Хүснэг №1. Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША-ы чанарын үзүүлэлт



Зураг №2. Хэл зохиолын хүрээлэнгийн ЭША-ы чанарын үзүүлэлт

Нийт албан хаагч	Үүнээс эмэгтэй	ЭША	35 хүртэлх насны	35-50 насны	50-аас дээш насны	Дундаж нас
50	22	47	17	19	14	42.6

Хүснэг №2. Хэл зохиолын хүрээлэнгийн нийт албан хаагчдын демографийн бүтэц



Зураг №3. Хэл зохиолын хүрээлэнгийн нийт албан хаагчдын насны бүтэц

2.2.3. Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны орц-гарцын шинжилгээ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нь 2017 оны байдлаар:

1. **Төсвийн нийт санхүүжилт 564.963.6 мянган төгрөг**
   - Цалин 476.666.0 мянган төгрөг
   - Нийгмийн даатгалын шимтгэл 52.433.2 мянган төгрөг
   - Суурь судалгааны 3 төсөл 25.542.0 мянган төгрөг

2. **Нэмэлт санхүүжилт**
   - Академич Д.Цэрэнсодном удирдагчтай судалгааны төсөл 10.000.0 мянган төгрөг
   - Академич Л.Болд удирдагчтай судалгааны төсөл 25.000.0 мянган төгрөг
   - “Эх хэл, бичиг” сэтгүүлийн хэвлэлийн зардал 2.000.0 мянган төгрөг
   - П.Хорлоогийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын дэмжлэг 2.430.0 мянган төгрөг

3. **Үйл ажиллагааны орлого:** 8.135.9 мянган төгрөг

гэсэн төсвийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Мөн түүнчлэн:

4. **ШУА-ийн грант** 2 төсөл 13.000.0 мянган төгрөг
   - Академич Л.Болд удирдагчтай төсөл 8.000.0 мянган төгрөг
   - Академич Д.Цэрэнсодном удирдагчтай төсөл 5.000.0 мянган төгрөг

зэрэг төсөл авч судалгаа боловсруулалтын ажил, түүний үр дүнг улам баяжуулж байна.

Энэхүү санхүүжилтийн хүрээнд болон хамтран ажилладаг байгууллагын санхүүжилтээр Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд 2017 онд нийт 76 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, 89 эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлж, 41 ном, товхимол, ганц сэдэвт бүтээл туурвижээ. Энд дурдсан дүн мэдээнээс үзвэл тооны хувьд хэн ч голох аргагүй байна. Гэвч чанарын талаас үзвэл 41 ном, товхимол, ганц сэдэвт бүтээлийн дотор дахин хэвлэгдсэн болон зохиогдоод олон жил болсоны эцэст хэвлэгдэж буй, эсхүл эрээвэр хураавар шинжтэй илтгэл, өгүүллийн эмхэтгэл бүтээл дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь хүрээлэнгийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулах, орц-гарцыг нарийвчлан төлөвлөх зайлшгүй шаардлагатай болсоныг тов тодорхой гэрчилж буй хэрэг юм.

2.2.4. Хүрээлэнгийн үйл ажиллагааны SWOT шинжилгээ

Гадаад орчин – Боломж	Гадаад орчин – Эрсдэл
- Монгол Улсад шинжлэх ухаан, инновацийг бүхий л төвшинд анхаарч, төр засгаас бодлогын баримт бичиг, хөтөлбөр, хууль баталсан нь эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг цаашид улам эрчимжүүлж байна. Энэ нь суурь болон хавсарга судалгаа, төсөл,	- Хүрээлэн дээр ахисан түвшний сургалтын үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчин бүрдээгүйгээс гадаадын их, дээд сургуулиудын хамтран ажиллах идэвх сонирхол тодорхой хэмжээгээр буурч буй - Хүрээлэнгийн эрдэм

грантыг дангаар болон дотоод, гадаадын хүрээлэн, төвүүдтэй хамтран хэрэгжүүлэх, үр дүнг түгээн дэлгэрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж байна. - Нөгөө талаар хүрээлэнгийн дотоод, гадаад харилцааны харилцааны уламжлал сайн, дотоод, гадаад дахь нэр хүнд өндөр хэвээр байгаа нь бидний боловсруулж буй энэхүү төлөвлөгөөний зорилт, үйл ажиллагааг биелүүлэн хэрэгжүүлэх нэгэн болмж гэж үзэж байна.	шинжилгээний ажилтан нарт тогтмол буюу тасралтгүй хугацаагаар их, дээд сургуульд хичээл заах, магистр, докторантын удирдагчаар олон удаа ажиллах боломж хязгаарлагдмал байдаг тул дэд профессор, профессор цолын болзлыг хангаж чадахгүй байна. Энэ нь гадаадын их, дээд сургуульд уригдан ажиллах боломжийг хаадаг - Хөрөнгө оруулалт, санхүүжилт хангалттай бус учир судалгааны цар хүрээ, үйл ажиллагаагаа тэлэх боломж хязгаартай
ДОТООД ОРЧИН – ДАВУУ ТАЛ	**ДОТООД ОРЧИН – СУЛ ТАЛ**
- Хүрээлэнгийн түүх, уламжлал, эрдэм шинжилгээний ажлын үндэс суурь сайтай - Дэлхийн монгол судлалын ертөнц хийгээд төр, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн судлаачид болон судалгааны бүтээлтэй - Ахмад академичид, тэргүүлэх зэргийн эрдэмтэд ажилласаар буй - Гадаад, дотоод харилцаа хамтын ажиллагааны талаар байгуулсан гэрээ хэлэлцээртэй - Улс нийгэмд тулгамдсан асуудлаар томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, шийдвэрлэж ирсэн туршлагатай	- Өөрийн бүтээгдэхүүнийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах талаар сул - Орчин үеийн онол арга зүй, техник технологийг эзэмших талаар хоцрогдмол - Залуу боловсон хүчний гадаад хэлний мэдлэг дутмаг - Санхүүжилтын эх үүсвэр хэт цөөн - Зах зээлд өрсөлдөх чадвар, маркетинг муу

ГУРАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ (2018-2025), ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ АШИГЛАХ, ЗАЛУУ СУДЛААЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ СИСТЕМТЭЙ ХӨГЖҮҮЛЭХ ЗАМААР ДЭЛХИЙН МОНГОЛ СУДЛАЛД ТЭРГҮҮЛЭХ ЭРДЭМТДИЙН ХАМТЛАГ БАЙХ

Байгууллагын өрсөлдөх чадварын гол үзүүлэлт нь хөдөлмөрийн бүтээмж бөгөөд үүнийг биелүүлэх үндсэн хүчин зүйл нь мэдлэг чадвар, дадлага туршлага тэгширсэн мэргэжилтэн юм. Тиймээс бид боловсон хүчний хөгжлийн асуудлыг бодлогын төвд тавьж байна.

Хэл зохиолын хүрээлэнгийн хувьд нийгэм, цаг үеийн тодорхой шалтгааны улмаас боловсон хүчний хөгжлийн бодлого, төлөвлөлт тасалдсан, ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоо суларсан, залуу судлаачид ажлын байран дээрээ өсөж хөгжих эрч саарсан, тогтвортой ажиллах итгэл үнэмшил буурсан зүйл бий.

Хэдий тийм боловч өнөөдөр дэлхийн монгол судлалын ертөнцөд хүлээн зөвшөөрөгдсөн академич Д.Төмөртогоо, Д.Цэрэнсодном, Л.Болд, доктор С.Байгалсайхан, Б.Катуу зэрэг эрдэмтэд манай эрдмийн хамт олныг манлайлан ажилласаар байна. Энэ нь ахмад академичдийн залгамж халааг богино хугацааны дотор амжиж бэлтгэх, дунд, залуу үеийн судлаачдыг судалгааны чиглэл бүр дээрээ тэргүүлэх эрдэмтэн болгож өсгөхөд хүрээлэнгийн дотоод нөөц бололцоо хангалттай хэмжээнд байгааг харуулж байна.

Энэхүү зорилтын хүрээнд бид хүн төвтэй удирдлагын стратегийг баримталж, онолын мэдлэг, судалгааны арга зүйг эзэмшсэн, бүтээлч сэтгэлгээтэй, хамтран ажиллах чадвартай боловсон хүчнээр бэхжиж, хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын чанар, бүтээмжийг эрс нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Үйл ажиллагааны зорилт 1.1. *Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх*

Үйл ажиллагааны зорилт 1.2. *Дунд үеийн судлаачдаа дэлхийн монгол судлалын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн чансаатай бүтээл туурвих нөхцөлөөр хангах*

Үйл ажиллагааны зорилт 1.3. *Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарыг гадаад ертөнцтэй холбох*

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2. СУДАЛГАА БОЛОВСРУУЛАЛТЫН АЖЛЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ БҮРЭН ХАНГАХ, МАТЕРИАЛЛАГ БААЗ СУУРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР МОНГОЛ ХЭЛ, УТГА ЗОХИОЛЫН ОНОЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ БҮРЭН ШИЙДВЭРЛЭХ

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн үр шим нь бидэнд өмнөх үеийн эрдэмтдийнхээ судалгааны хүрсэн түвшинг цааш ахиулахад олон давуу талыг олгохын зэрэгцээ эх хэрэглэгдэхүүнээ бүртгэн цуглуулах, тус тусын чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаатай бөгөөд бүрэн хэмжээний баримт нотолгоонд суурилсан үр дүн гаргахыг зүй ёсоор шаардаж байна. Энэ чиглэлээр манай хүрээлэн “Монголын уран зохиолын дээж 108 ботийн цахим сан”, “Монгол хэлний цахим их тайлбар толь” зэрэг мэдээллийн санг бүрдүүлж, эрдэм шинжилгээний хийгээд олон нийтийн хэрэгцээнд нийлүүлээд байгаа юм.

Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын цаашид хүлээн зөвшөөрөгдөх баталгааг хангах үүднээс хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэлийн дагуу мэдээллийн сан бүрдүүлэх, зөөлөн ба хатуу тоног төхөөрөмжийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үйл ажиллагааны зорилт 2.1. *Судалгаа боловсруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангах тогтолцоог сайжруулах*

Үйл ажиллагааны зорилт 2.2. *Монгол хэл, утга соёлын талаарх бодлогын баримт бичиг боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт санаачилгатай оролцох*

Үйл ажиллагааны зорилт 2.3. *Судалгааны ажил хийх материаллаг бааз суурийг бэхжүүлж, монгол хэл, утга соёл судлалын иж бүрэн мэдээллийн сан бүрдүүлэх*

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖТЭЙ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нь XX зууны Монгол улсад орчин цагийн хэл зүй, үгийн сан, толь бичгийн иж бүрэн судалгаа, Монголын эртний болон орчин үеийн бичгийн уран зохиол, аман зохиолын цогц судалгааг төлөвшүүлэн хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн.

Цаашид нийгмийн хөгжил дэвшилд тулгамждаж буй асуудлаар эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий, эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд онцгой анхааран ажиллана. Түүнчлэн, бид эрдэм судлалын ажлынхаа үр дүнг түгээж ирсэн туршлагаа эргэн харвал нэлээд хязгаарлагдмал байна. Ялангуяа бидний сүүлийн үеийн судалгаа боловсруулалтын ажил, түүний үр дүнгийн талаар төр, олон нийтийн байгууллага, ард иргэд тийм ч тодорхой ойлголттой болж чадаагүй байсаар байна. Тиймээс бид судалгаа боловсруулалтын ажлын үр дүнгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийг тусгай стратегийн зорилт болгон оруулж байна. Үүнд хэвлэмэл хувилбараас гадна, олон нийтийн мэдээлэл харилцааны бүхий л талбар (платформ)-ууд дээр, тус бүрд нь зохицсон хэлбэрээр байршуулахаар төлөвлөж байна.

Үйл ажиллагааны зорилт 3.1. *Хүрээлэнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх*

Үйл ажиллагааны зорилт 3.2. *Судалгаа боловсруулалтын үр дүнгээр шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох*

СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4. ДОТООД, ГАДААД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ИДЭВХТЭЙ ӨРНҮҮЛЭХ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн нь дэлхийн монгол судлалын төвүүдтэй хамтран ажиллаж, судалгааныхаа үндсэн чиглэлийн дагуу төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх замаар санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, боловсон хүчнийхээ нэр төр, мэдлэг чадварыг улам ахиулан ажиллана.

Үйл ажиллагааны зорилт 4.1. *Дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх*

Үйл ажиллагааны зорилт 4.2. *Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх*

ДӨРӨВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД

Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь 2 үе шаттайгаар хэрэгжинэ. Дунд хугацааны хүрээлэнгийн хөгжлийн төлөвлөгөө нь 4 жилийн хугацаатай ШУА-ийн Ерөнхийлөгч болон Хүрээлэнгийн захирлын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр дээр суурилсан байна. Богино хугацааны үе шат нь Хүрээлэнгийн 1 жилийн үр дүнгийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болно.

4.1. Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө

Хэл зохиолын хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хүрээлэнгийн захирлын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг үндэслэн боловсруулж ШУА-ийн Ерөнхийлөгчөөр батлуулсан. Хүрээлэнгийн судалгаа боловсруулалтын ирэх 4 жилд хөгжүүлэн өргөжүүлэх төлөвлөгөөг тус хөтөлбөрт суурилж, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/, ШУА-ийн Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны хөтөлбөр, бусад эрх зүйн баримт бичгүүд, улс орны нийгэм, эдийн засгийн болон техник технологийн хөгжлийн төлөвт нийцүүлж, нийгмийн оюун санааны чиг хандлагатай уялдуулан боловсруулна. Хөгжлийн төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг тусгана. Үүнд:

- Хүрээлэнгийн судалгаа боловсруулалтын ажлын үндсэн чиглэл, тэргүүлэх чиглэлийг тодотгох
- Хүрээлэнгийн бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Хүрээлэнгээс хэрэгжүүлэх судалгаа боловсруулалтын үр дүнгээр онолын судалгааны хүрсэн төвшинг улам ахиулахын зэрэгцээ инновацийн бүтээгдэхүүн болгох замаар амьдрал хэрэглээнд нэвтрүүлэх зохицуулалтыг бий болгох
- Хүрээлэнгийн судалгаа боловсруулалтын ажлын санхүүжилтийг тогтвортой нэмэгдүүлэх, олон эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг эрэлхийлэх
- Хүрээлэнгийн хүний нөөцийг тогтвортой хөгжүүлэх бодлогыг боловсруулж, чадварлаг шинэ залуу эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, эрдэмтэн судлаачдын бүтээлч ажиллагааг дэмжиж

- Их, дээд сургуультай боловсролыг болон судалгааны чиглэлээр хамтран ажиллах, хамтарсан төсөл, сургалт, семинар, хөтөлбөр хэрэгжүүлэх
- Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ хамтын ажиллагааг эхлүүлэх асуудлыг дэмжих зэрэг асуудал болно.

4.2. Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээний төлөвлөгөө

Хүрээлэнгийн нэг жилийн үр дүнгийн гэрээ болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ШУА- ийн Тэргүүлэгчдийн газраас гаргасан удирдамж чиглэлийн дагуу Хүрээлэнгийн 4 жилийн хөгжлийн төлөвлөгөө, Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөний хүрээнд жил тутам боловсруулна.

ТАВ. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ХҮРЭЭ, БОЛОМЖ

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн хүрээг гадаад болон дотоод, оюуны болон биет хөрөнгө оруулалт гэсэн хэсгүүдээр тодорхойлж байна.

5.1. Дотоод хүрээ, боломж

Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих шинэ сэдэв, төслүүдийг нийгэм нийтийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглүүлэх, үр дүн нь асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хэрэгжих боломжтой шийдлийг гаргасан байх, энэ нь шууд болон шууд бус хэлбэрээр бүтээгдэхүүн болж үр ашгаа өгдөг байхаар боловсруулан улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Бид онолын суурь судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлэх, дуун ухааны сан хөмрөгийн хадгаламжаас эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах замаар сургалт, эрдэм шинжилгээний хүрээнээс, аман зохиолын эх хэрэглэгдэхүүнээс сурган хүмүүжүүлэх ач холбогдол бүхий хэсгийг олон төрөл хэлбэрээр хэвлэн нийтэлж ард нийтэд хүргэх, монгол хэлний хэрэглээний хэм хэмжээ, хэлний соёлыг хүүхэд залууст эзэмшүүлэх ач холбогдол бүхий сургалт сутралчилгааны бүтээгдэхүүнийг нийлүүлэх замаар өөрийн үйл ажиллагаанаас жилдээ 50-80 сая төгрөгийн орлого олж, Хүрээлэнгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн үндсэн эх үүсвэрийг бий болгоно.

5.2. Гадаад хүрээ, боломж

Тус Хүрээлэнгийн монгол хэл, утга зохиолын онолын суурь судалгааны үр дүнгүүд, монгол болон төвд хэлт сурвалж бичгийн судалгаа, монгол, тод, төвд сурвалж бичиг, монгол хэлний нутгийн аялгуу, аман зохиолын эх хэрэглэгдэхүүний баялаг сан хөмрөг, сургалт сурталчилгааны бүтээлүүд нь дэлхийн монгол судлалын анхаарлыг ямагт нааш татсаар байдаг юм.

Бид онолын суурь судалгааны хамрах хүрээгээ улам өргөтгөх, дуун ухааны сан хөмрөгийн хадгаламжаас эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах замаар жилдээ 30-60 мянган ам.долларын санхүүжилтийг гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх сангаас олох боломжтой гэж үзэж байна.

ЗУРГАА. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

6.1. Стратеги зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтууд, төлөвлөгөөт арга хэмжээ

Стратегийн зорилтууд	Үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ
I. Хүний нөөцийг оновчтой ашиглах, залуу судлаачдын мэдлэг чадварыг системтэй хөгжүүлэх замаар дэлхийн монгол судлалд тэргүүлэх эрдэмтдийн хамтлаг байх	1.1. Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх	1.1.1. Ахмад эрдэмтдэд залуу судлаачдыг дагалдуулан сургаж эрдэмжүүлэх 1.1.2. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн монголын хэл, утга зохиол судлалын дэг сургуулийг хөгжүүлэх 1.1.3. Гурван үеийн эрдэмтэд оролцсон онол-арга зүйн семинар, хүндэт докторын лекцийг тогтмол явуулж, залуу судлаачдын өсөлт бэхжилтэнд түлхэц үзүүлэх
	1.2. Дунд үеийн судлаачдаа дэлхийн монгол судлалын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн чансаатай бүтээл туурвих нөхцөлөөр хангах	1.2.1. Төсөл удирдан хэрэгжүүлэх санаачилгыг бүх талаар дэмжиж, суурь болон хавсарга судалгааны төсөл, грант, захиалгат судалгааг хүрээлэн дангаар болон дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 1.2.2. Суурь болон хавсарга судалгааны үр дүнгээ мэдээлэл сурталчилгааны бүхий л талбараар дамжуулан олон нийтэд хүргэж боловсон хүчнийхээ нэр төр, нийгэм дэх байр суурийг улам өргөтгөн бэхжүүлэх 1.2.3. Гадаадад явах албан томилолт, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцох тоог нэмэгдүүлж, хамтын бүтээлийн тоо, чанарыг ахиулах

	1.3. Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарыг гадаад ертөнцтэй холбох	1.3.1. Гадаад хэлнээс онолын өгүүлэл орчуулах, гадаад хэлээр өгүүлэл бичих сургалт зохион дадлагажуулах замаар импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх болоцоог бүрдүүлэх 1.3.2. Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад богино хугацаагаар ажиллаж мэргэжил дээшлүүлэх 1.3.3. Залуу судлаачдын санаачилгаар гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас залуу судлаачдыг түр хугацаагаар урьж ажиллуулах
II. Судалгаа боловсруулалтын ажлыг оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийг бүрэн хангах, материаллаг бааз суурийг бэхжүүлэх замаар монгол хэл, утга зохиолын онол, хэрэглээний тулгамдсан асуудлуудыг бүрэн шийдвэрлэх	2.1. Судалгаа боловсруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангах тогтолцоог сайжруулах	2.1.1. Хүрээлэнгийн бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх 2.1.2. Суурь болон хавсарга судалгааны төсөл, грант, захиалгат судалгааны боловсруулалт, үр өгөөж, гүйцэтгэлийн явц, завсарын үр дүнд тавих хяналтыг тогтмолжуулах 2.1.3. Нийгэм дэх монгол хэлний хэрэглээний тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн захиалгат төслийн тоог нэмэгдүүлэх
	2.2. Монгол хэл, утга соёлын талаарх бодлогын баримт бичиг боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт санаачилгатай оролцох	2.2.1. Эх хэл, утга соёлыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж болох шинжлэх ухаан, эдийн засгийн үр дүнтэй сэдвийн жагсаалт, үндэслэлийг боловсруулж төр засгийн байгууллагуудад хүргүүлэх 2.2.2. Монгол хэл, утга зохиолын талаар баримтлах бодлогын асуудалд мэдээлэл, зөвлөмж боловсруулах 2.2.3. “Монгол хэлний тухай

		хууль”-аар оногдсон үүргээ биелүүлэх талаар шат дараалсан ажил, арга хэмжээ зохион байгуулах
	2.3. Судалгааны ажил хийх материаллаг бааз суурийг бэхжүүлж, монгол хэл, утга соёл судлалын иж бүрэн мэдээллийн сан бүрдүүлэх	2.3.1. Судалгаа боловсруулалтын ажил хийх техник хэрэгсэл, зөөлөн ба хатуу тоноглолын бааз суурийг бэхжүүлэх 2.3.2. Монгол хэл, утга соёл судлалын эрдэм шинжилгээний бүтээлийн болон эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх 2.3.3. Хүрээлэнгээс эрхлэн гаргаж буй сэтгүүл, ганц сэдэвт бүтээлийн эрдэм шинжилгээний чанар чансааг ахиулж, цаашид цахим хэлбэрт шилжүүлэн судалгааны сан /digital database/ байгуулах
III. Эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий, эдийн засгийн үр өгөөжтэй төсөл хэрэгжүүлэх	3.1. Хүрээлэнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	3.1.1. Монгол хэл, утга зохиол судлалын онолын гүнзгийрсэн судалгаанд дотоод болон гадаадын шинжлэх ухааны төслийг санхүүжүүлэгч байгууллагын дэмжлэгийг олж ажиллах 3.1.2. Эх хэл, утга соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төсөл боловсруулж санхүүжилтийг холбогдох төр засгийн болон олон улсын байгууллагаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх 3.1.3. Шинэ мэдлэг шингэсэн, үндэсний онцлог бүхий шийдэлтэй инновацийн бүтээгдэхүүн бий болгоход хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын татах

	3.2. Судалгаа боловсруулалтын үр дүнгээр шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох	3.2.1. Олон нийтийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээний төрлийг шинээр буй болгох 3.2.2. Төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч “Монгол контент” бүтээх 3.2.3. Монгол хэл болон гадаад хэлний зүй тогтлыг түгээмэл хэл зүйн үүднээс зэрэгцүүлэн судалсан, хэрэглээний үр өгөөж бүхий сурах бичиг, гарын авлага бүтээж нийтийн хэрэгцээнд нийлүүлэх
IV. Дотоод, гадаад эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх	4.1. Дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх	4.1.1. Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээг уламжлан үргэлжлүүлэх, сунгах, шинээр байгуулах 4.1.2. Суурь болон хавсарга судалгааны хамтарсан төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх 4.1.3. Монгол контент бүтээх төслүүдийг хамтран хэрэгжүүлэх
	4.2. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх	4.2.1. Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээг уламжлан үргэлжлүүлэх, сунгах, шинээр байгуулах 4.2.2. Хүрээлэнгийн дэргэд орон тооны бус гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төслийн баг ажиллуулах 4.2.3. Өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, албан ёсны лицензтэй програм хангамж бүхий хамтарсан лаборатори байгуулж, инновацийн бүтээгдэхүүн гаргах 4.2.4. Суурь болон хавсарга судалгааны хамтарсан төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх 4.2.5. Олон улсын мэргэжлийн холбоо, сүлжээнд гишүүн байгууллагаар элсэх

6.2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгө, санхүүжилт

№	Үйл ажиллагааны зорилтууд	Шаардагдах хөрөнгийн хэмжээ (сая төг.)	Үүнээс санхүүжилтийн эх үүсвэр (%)			
			Улсын төсөв	Гадаадын төсөл, хөтөлбөр	Байгууллагын санхүүжилт	Бусад
Стратегийн зорилт I. Хүний нөөцийг оновчтой ашиглах, залуу судлаачдын мэдлэг чадварыг системтэй хөгжүүлэх замаар дэлхийн монгол судлалд тэргүүлэх эрдэмтдийн хамтлаг байх						
1.1	Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх	150.0	130.0	20.0	10.0	-
1.2	Дунд үеийн судлаачдаа дэлхийн монгол судлалын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн чансаатай бүтээл туурвих нөхцөлөөр хангах	400.0	250.0	60.0	40.0	50.0
1.3	Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарыг гадаад ертөнцтэй холбох	200.0	120.0	30.0	30.0	20.0
Стратегийн зорилт II. Судалгаа боловсруулалтын ажлыг оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийг бүрэн хангах, материаллаг бааз суурийг бэхжүүлэх замаар монгол хэл, утга зохиолын онол, хэрэглээний тулгамдсан асуудлуудыг бүрэн шийдвэрлэх						
2.1	Судалгаа боловсруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангах тогтолцоог сайжруулах	250.0	200.0	-	30.0	20.0
2.2	Монгол хэл, утга соёлын талаарх бодлогын баримт	350.0	300.0		50.0	

	бичиг боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт санаачилгатай оролцох					
2.3	Судалгааны ажил хийх материаллаг бааз суурийг бэхжүүлж, монгол хэл, утга соёл судлалын иж бүрэн мэдээллийн сан бүрдүүлэх	480.0	200.0	200.0	60.0	20.0
Стратегийн зорилт III. Эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий, эдийн засгийн үр өгөөжтэй төсөл хэрэгжүүлэх						
3.1	Хүрээлэнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	100.0	-	20.0	50.0	30.0
3.2	Судалгаа боловсруулалтын үр дүнгээр шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох	200.0	110.0	10.0	40.0	40.0
Стратегийн зорилт IV. Дотоод, гадаад эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх						
4.1	Дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх	-	-	-	-	-
4.2	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх	-	-	-	-	

6.3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Стратеги төлөвлөгөөний үйл ажиллагааны зорилтууд	Хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017)	Хүрэх түвшин	
					I үе шат	II үе шат
1	Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог бэхжүүлэх	1.1. Ахмад эрдэмтдэд залуу судлаачдыг дагалдуулан сургаж эрдэмжүүлэх	Тоо	2	10	10
		1.2. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн монголын хэл, утга зохиол судлалын дэг сургуулийг хөгжүүлэх	Тоо	гүйцэтгэлээр		
		1.3. Гурван үеийн эрдэмтэд оролцсон онол-арга зүйн семинар, хүндэт докторын лекцийг тогтмол явуулж, залуу судлаачдын өсөлт бэхжилтэнд түлхэц үзүүлэх	Тоо	2	12	16
2	Дунд үеийн судлаачдаа дэлхийн монгол судлалын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн чансаатай бүтээл туурвих нөхцөлөөр хангах	2.1. Төсөл удирдан хэрэгжүүлэх санаачилгыг бүх талаар дэмжиж, суурь болон хавсарга судалгааны төсөл, грант, захиалгат судалгааг хүрээлэн дангаар болон дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Тоо	1	12	16
		2.2. Суурь болон хавсарга судалгааны үр дүнгээ мэдээлэл сурталчилгааны бүхий л талбараар дамжуулан олон нийтэд хүргэж боловсон хүчнийхээ нэр төр, нийгэм дэх байр суурийг улам өргөтгөн бэхжүүлэх	Тоо	гүйцэтгэлээр		

		2.3. Гадаадад явах албан томилолт, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцох тоог нэмэгдүүлж, хамтын бүтээлийн тоо, чанарыг ахиулах	Тоо	20	120	120
3	Эрдэм шинжилгээний залуу ажилтан нарыг гадаад ертөнцтэй холбох	3.1. Гадаад хэлнээс онолын өгүүлэл орчуулах, гадаад хэлээр өгүүлэл бичих сургалт зохион дадлагажуулах замаар импакт фактор бүхий мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх болоцоог бүрдүүлэх	Тоо	2	12	20
		3.2. Гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад богино хугацаагаар ажиллаж мэргэжил дээшлүүлэх	Тоо	10	80	120
		3.3. Залуу судлаачдын санаачилгаар гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас залуу судлаачдыг түр хугацаагаар урьж ажиллуулах	Тоо	-	8	12
4	Судалгаа боловсруулалтын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангах тогтолцоог сайжруулах	4.1. Хүрээлэнгийн бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх	Тоо	-	гүйцэтгэлээр	
		4.2. Суурь болон хавсарга судалгааны төсөл, грант, захиалгат судалгааны боловсруулалт, үр өгөөж, гүйцэтгэлийн явц, завсарын үр дүнд тавих хяналтыг тогтмолжуулах	Тоо	3	12	12

		4.3. Нийгэм дэх монгол хэлний хэрэглээний тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн захиалгат төслийн тоог нэмэгдүүлэх	Тоо	1	16	20
5	Монгол хэл, утга соёлын талаарх бодлогын баримт бичиг боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх үйл хэрэгт санаачилгатай оролцох	5.1. Эх хэл, утга соёлыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж болох шинжлэх ухаан, эдийн засгийн үр дүнтэй сэдвийн жагсаалт, үндэслэлийг боловсруулж төр засгийн байгууллагуудад хүргүүлэх	Тоо	гүйцэтгэлээр		
		5.2. Монгол хэл, утга зохиолын талаар баримтлах бодлогын асуудалд мэдээлэл, зөвлөмж боловсруулах	Тоо	гүйцэтгэлээр		
		5.3. “Монгол хэлний тухай хууль”-аар оногдсон үүргээ биелүүлэх талаар шат дараалсан ажил, арга хэмжээ зохион байгуулах	Тоо	70	гүйцэтгэлээр	
6	Судалгааны ажил хийх материаллаг бааз суурийг бэхжүүлж, монгол хэл, утга соёл судлалын иж бүрэн мэдээллийн сан бүрдүүлэх	6.1. Судалгаа боловсруулалтын ажил хийх техник хэрэгсэл, зөөлөн ба хатуу тоноглолын бааз суурийг бэхжүүлэх	Тоо	гүйцэтгэлээр		
		6.2. Монгол хэл, утга соёл судлалын эрдэм шинжилгээний бүтээлийн болон эх хэрэглэгдэхүүний сан бүрдүүлэх	Тоо	2	4	4

		6.3. Хүрээлэнгээс эрхлэн гаргаж буй сэтгүүл, ганц сэдэвт бүтээлийн эрдэм шинжилгээний чанар чансааг ахиулж, цаашид цахим хэлбэрт шилжүүлэн судалгааны сан /digital database/ байгуулах	Тоо	-	5	-
7	Хүрээлэнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	7.1. Монгол хэл, утга зохиол судлалын онолын гүнзгийрсэн судалгаанд дотоод болон гадаадын шинжлэх ухааны төслийг санхүүжүүлэгч байгууллагын дэмжлэгийг олж ажиллах	Тоо	гүйцэтгэлээр		
		7.2. Эх хэл, утга соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр төсөл боловсруулж санхүүжилтийг холбогдох төр засгийн болон олон улсын байгууллагаар шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх	Тоо	-	8	8
		7.3. Шинэ мэдлэг шингэсэн, үндэсний онцлог бүхий шийдэлтэй инновацийн бүтээгдэхүүн бий болгоход хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын татах	Тоо	гүйцэтгэлээр		
8	Судалгаа боловсруулалтын үр дүнгээр шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох	8.1. Олон нийтийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээний төрлийг шинээр буй болгох	Тоо	-	8	8

		8.2. Төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч “Монгол контент” бүтээх	Тоо	-	4	6
		8.3. Монгол хэл болон гадаад хэлний зүй тогтлыг түгээмэл хэл зүйн үүднээс зэрэгцүүлэн судалсан, хэрэглээний үр өгөөж бүхий сурах бичиг, гарын авлага бүтээж нийтийн хэрэгцээнд нийлүүлэх	Тоо	1	6	8
9	Дотоод хамтын ажиллагааг идэвхжүүлэх	9.1. Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээг уламжлан үргэлжлүүлэх, сунгах, шинээр байгуулах	Тоо	1	8	8
		9.2. Суурь болон хавсарга судалгааны хамтарсан төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх	Тоо	-	2	3
		9.3. Монгол контент бүтээх төслүүдийг хамтран хэрэгжүүлэх	Тоо	гүйцэтгэлээр		
10	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх	10.1. Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээг уламжлан үргэлжлүүлэх, сунгах, шинээр байгуулах	Тоо	4	20	20
		10.2. Хүрээлэнгийн дэргэд орон тооны бус гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төслийн баг ажиллуулах	Тоо	-	4	4
		10.3. Өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, албан ёсны лицензтэй програм хангамж бүхий хамтарсан лаборатори байгуулж, инновацийн бүтээгдэхүүн гаргах	Тоо	1	2	2

		10.4. Суурь болон хавсарга судалгааны хамтарсан төсөл хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх	Тоо	1	8	8
		10.5. Олон улсын мэргэжлийн холбоо, сүлжээнд гишүүн байгууллагаар элсэх	Тоо	гүйцэтгэлээр		

ХАВСРАЛТ

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор, профессор Г.Билгүүдэйн үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт	Хийгдэх ажлууд	Хугацаа (жилээр)				Дүгнэх гол үзүүлэлтүүд	Тайлбар /Хүрэх үр дүн/
			2017	*2018*	*2019*	*2020*		
А	*Б*	*В*	*1*	*2*	*3*	*4*	*5*	*6*
1.	**Зорилго-1.** *Нийгэм, зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангасан чанартай судалгаа боловсруулалтыг хийх, удирдлага, менежментийг сайжруулах замаар хүрээлэнгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх*	1. Судалгааны тэргүүлэх чиглэлийг оновчтой тодорхойлох	+				*Тодорхойлсон судалгааны тэргүүлэх чиглэлийн тоо*	*Дотоод, гадаадын зах зээлийн эрэлт, шаардлаганд нийцсэн шинэ мэдлэг бий болгох, эцсийн бүтээгдэхүүн байнга нийлүүлэх нөхцөл бүрдэн, хүрээлэнгийн нэр хүнд, байр суурь өсч, өрсөлдөх чадвар дээшилнэ.*
		2. Удирдлага, менежментийг боловсронгуй болгох үүднээс хүрээлэнгийн дүрэм, дотоод журмыг шинэчлэх.	+				*Шинэчилсэн дүрэм, журмын тоо*	
		3. Хэтийн болон бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд жилд 5-аас доошгүй ном, товхимол хэвлүүлэх./Нийт 20/	5	5	5	5	*-Боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн тоо -Хэвлүүлсэн ном, бүтээлийн тоо*	
		4. Хүрээлэнгээс эрхлэн гаргаж буй сэтгүүл, ганц сэдэвт бүтээлийн эрдэм шинжилгээний чанар чансааг ахиулж, цаашид цахим хэлбэрт шилжүүлэн	+	+	+	+	*-Хэвлэгдсэн сэтгүүл, ганц сэдэвт бүтээлийн тоо*	

		судалгааны сан /digital database/ байгуулах.					*-Цахим хэлбэрт оруулсан ном, бүтээлийн тоо*	
		5. Нийгэмд үйлчлэх, мэдлэг түгээх, хүрээлэнгийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг эрчимжүүлэх зорилгоор хүрээлэнгийн вэбсайтыг бүрэн шинэчилж, тогтмол мэдээллээр баяжуулна. Нийгмийн цахим сүлжээг өргөн ашиглах /facebook, twitter гэх мэт/.	+	+	+	+	*-Вэбсайт баяжуулалтын тоо*	
2	**Зорилго-2.** *Эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн чанар, үр ашгийг дээшлүүлж, ажилтнуудын ажлын үр дүнг хянах-үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох.*	1. Судалгааны ажлын үр дүнг үнэлэх, урамшуулах, хариуцлага тооцох шалгуур үзүүлэлтүүдийг улам боловсронгуй болгож, ажилтнуудын улирал, жилийн ажлыг дүгнэхдээ мөрдлөг болгож, ЭША-ы аттестачлалд системтэй бэлтгэх ажлыг зохион байгуулна.	+	+	+	+	*-Боловсруулсан шалгуур үзүүлэлтүүд* *-Ажлыг дүгнэсэн баримт бичиг*	*Ажил хэрэгч, шударга орчин, ил тод байдал сайжирна.*
		2. Суурь судалгааны сэдэвт ажил, ШУТ-ийн төслийн боловсруулалт, үр өгөөж, гүйцэтгэлийн явц, завсарын үр дүнд тавих хяналтыг эрс сайжруулах.	+	+	+	+	*-Сэдэвт ажил, төслийг боловсруулах, явцын үр дүнг хянах журам*	
		3. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд янз бүрийн хэлбэрээр /интернет гэх мэт/ борлуулах замаар ажилтнуудын ажиллах сонирхлыг материаллаг хөшүүрэгтэй хослуулах.		+	+	+	*-Ажилтнуудын дунд эцсийн бүтээгдэхүүн гаргах, борлуулах урамшууллын журам*	

		4. Нэмэлт санхүүжилтээр хийгдэх /өөрийн орлого, захиалгат судалгаа, тендер, хамтарсан төсөл, хандив тусламж гэх мэт/ судалгааны ажлын хувийн жинг хүрээлэнгийн жилийн төсвийн 20-30 хувьтай тэнцэх хэмжээнд хүргэх.		+	+	+	*-Нэмэлт санхүүжилтийн хувь*	
3.	**Зорилго-3** *Хүний нөөцийг оновчтой ашиглах, ажилтнуудын мэдлэг, чадавхийг системтэй дээшлүүлэн, нийгмийн хамгааллыг сайжруулах*	1. Судлаачдын залуу үеийг бэлтгэхийн тулд дэс дараатай арга хэмжээ хэрэгжүүлнэ. Эрдэм шинжилгээний залуу ажилтны гадаад хэлний (англи, орос, хятад) мэдлэгийг дээшлүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлэх. Гадаадын их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудад мэргэжил дээшлүүлэх ажилтны тоог нэмэгдүүлэх.	+	+	+	+	*-Гадаад хэлний сургалт, дамжаанд хамрагдсан ажилтны тоо -Гадаадад мэргэжил дээшлүүлсэн хүний тоо*	*Хүрээлэнгийн ажилтнуудын боловсрол, ур чадвар бодитой дээшилж, бие даан судалгаа явуулах эрдэмтдийн хувийн жин нэмэгдэнэ. Ажилтнуудын нийгмийн хамгаалал, ажиллах нөхцөл сайжирна.*
		2. Жил бүр залуу ажилтнуудын шилдэг бүтээлийн уралдаан зарлаж, түрүүлсэн ажилтанд захирлын нэрэмжит шагналаар урамшуулах.	+	+	+	+	*-Захирлын нэрэмжит шагнал олгох журам -Шагнагдсан хүний тоо*	
		3. Ажилтнуудын эрдмийн зэрэг хамгаалах идэвх санаачлагыг бүх талаар дэмжих.	+	+	+	+	*-Sc.D, Ph.D болон магистрын зэрэг хамгаалсан хүний тоо*	
		4. Хүрээлэнгийн ажилтны гадаадад явах албан томилолт, олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж оролцох тоог нэмэгдүүлж,					*-Албан томилолтоор явсан, олон улсын хуралд илтгэл*	

		хамтын бүтээлийн тоо, чанарыг ахиулах.					*хэлэлцүүлсэн хүний тоо* *-Хамтын бүтээлийн тоо*	
		5. “Шувууны үүр” хөтөлбөрийн хүрээнд гадаадад ажиллаж буй монгол эрдэмтэд, мөн сурч буй докторант, магистрантуудтай байнгын хэлхээ холбоо тогтоон, идэвхитэй хамтран ажиллах.	+	+	+	+	*-Хамтран ажилласан эрдэмтдийн тоо*	
		6. Онол-арга зүйн болон эрдэм шинжилгээний семинар, хүндэт докторын лекцийг тогтмол явуулж, залуу судлаачдын өсөлт бэхжилтэнд түлхэц үзүүлэх.	+	+	+	+	-Зохион байгуулсан семинар, лекцийн тоо	
		7. Ажилтнуудын нийгмийн хамгаалал, ажиллах нөхцлийг сайжруулахын тулд дотоод, гадаад нөөц бололцоог ашиглах, түүний дотор хандив, тусламж, захиалгат судалгаа, хамтарсан төслүүдээс олох орлогын тодорхой хувийг энэ зорилгонд хуримтлал үүсгэх ажлыг эхлүүлэх.	+	+	+	+	*-Ажилтнуудын нийгмийн хамгаалал, ажиллах нөхцөл сайжируулахад зарцуулсан хөрөнгийн -хуриимтлалын хэмжээ*	

4.	**Зорилго-4** *Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн идэвхижүүлж, үр нөлөөг дээшлүүлэх*	1. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ хүрээлэнгийн судалгааны тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, боловсон хүчний мэдлэгийн чадварыг дээшлүүлэхэд анхаарах.	+	+	+	+	*-Гадаадтай хамтарсан хурал, төсөл, бүтээлийн тоо* *-Санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ*	*Хүрээлэнгийн ажилтнууд бүтээлээ олон улсын түвшинд үнэлүүлэх, гадаад зах зээлд хүргэх, хамтарсан төсөл, хөтөлбөрт хамрагдах өргөн боломж нээгдэнэ.*
		2. Хамтран ажиллагч гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын хөрөнгө оруулалтад түшиглэн, өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж, боловсронгуй программ хангамж бүхий хамтарсан лаборатори байгуулж, инновацийн бүтээгдэхүүн гаргах эхлэлийг тавих.	+	+	+	+	*-Байгуулсан лаборатори, гаргасан бүтээгдэхүүний тоо*	
		3. Хүрээлэнгийн дэргэд орон тооны бус гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төслийн баг ажиллуулж, янз бүрийн төслийн санал боловсруулах, санхүүгийн эх сурвалж хайх ажлыг хариуцуулах.	+	+	+	+	*-Боловсруулж мэдүүлсэн, санхүүжилт авсан төслийн тоо*	

		4. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээг уламжлан үргэлжлүүлэх, сунгах, шинээр байгуулах.	+	+	+	+	*-Гэрээ хэлэлцээг сунгасан болон шинээр хамтран ажилласан байгууллагын тоо*	
		5. Гадаад орнуудаас Монгол улсад ирж судалгаа хийх сонирхолтой эрдэмтэд, залуу судлаачдыг урьж түр хугацаагаар ажиллуулах ажлыг идэвхижүүлэх.	+	+	+	+	*-Хүрээлэнд ирж ажилласан эрдэмтдийн тоо*	
		6. Олон улсын мэргэжлийн холбоо, сүлжээнд гишүүн байгууллагаар элсэх боломжийг эрэлхийлэх.	+	+	+	+	*-Гишүүнээр элссэн олон улсын мэргэжлийн холбооны тоо*	